

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ БА БНХАУ-ЫН ХҮЧИН ЗҮЙЛ

*Д.Шүрхүү**

Миний илтгэлийн гол зорилго бол сүүлийн жилүүдэд Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын талаар бодлого тодорхойлогч улс төрчид, томоохон эдийн засагчид, мэргэжилтнүүдийн хийсэн судалгаанд¹ түшиглэн Монгол, Хятадын худалдаа, эдийн засгийн харилцаа, БНХАУ-ын өнөөгийн байдалд боломжийнхоо түвшинд дүн шинжилгээ хийх замаар Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд улс төр, эдийн засгийн хүч нөлөө нь жилээс жилд өсөн нэмэгдсээр буй БНХАУ-ын зүгээс үзүүлэх нөлөө, хүчин зүйлийг өнгөрсөн, одоо, ирээдүйн солбилцлын дунд тодруулан гаргах оролдлого хийх явдал байлаа. Эдийн засгийн аюулгүй байдал хэмээх асар өргөн хүрээг хамарсан нарийн төвөгтэй асуудлыг хөрш их гүрний харилцаатай холбон, дэлхийн болон бүс нутгийн улс төр, эдийн засгийн хувьсал өөрчлөлтийн дунд судалбаас өөрийн эрхгүй улс төрийн бодлого, геополитикийн хүчин зүйлүүдтэй нягт уялдаж байна. Өөрөөр хэлбэл улс орны тусгаар тогтнол, бүрэн эрх, бие даасан байдал зэрэг язгуур эрх ашигтай шууд холбоотой гэсэн үг юм.

Монгол-Хятадын улс төрийн харилцаа хамгийн тааламжтай, хамгийн сайн байгаа хэмээн хоёр тал үзэж буй өнөө үед манай эдийн засгийн аюулгүй байдалд БНХАУ ямар нөлөө үзүүлж байгаа, цаашид эерэг, сөрөг хүчин зүйлийн аль нь давамгайлах вэ, хэрэв сөрөг талууд нь нэмэгдвэл хэрхэн даван туулах вэ гэдэг асуудал улс төрчид, судлаачид төдийгүй жирийн иргэдийн анхаарал сонирхлыг ч зүй ёсоор татсаар байна.

Манайд нөлөөлөх хүчин зүйлийг нь авч үзэхийн өмнө БНХАУ-ын талаарх зарим чухал тоо баримт, мэдээллийг цухас дурьдмаар байна. Хятад орны нам төрийн дээд удирдлагад гарч ирсэн шинэ эрх баригчид коммунист төвлөрсөн удирдлагыг зах зээлийн эдийн засагтай хослуулах замаар дэлхийн хүчирхэг гүрэн болох зорилгын дор явуулж буй өргөн хүрээтэй “туршилт”-ыг хэрхэн үргэлжлүүлэх, амжилтанд хүрэх эсэхийг гадаадын ажиглагчид, хятад судлаачид тал бүрээс нь нарийвчлан судалсаар байна. Эдүгээ Хятад улсын эдийн засгийн цар хүрээ нь үндэсний нийт орлого гэсэн үзүүлэлтээр (1132.2 тэрбум ам.долл)² дэлхийд 6-рт, худалдан авах чадвар (5989.0 тэрбум ам.долл)³

*Д.Шүрхүү - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

хэмээх үзүүлэлтээр бол бүр 2-рт орж байна. Хятадын гаалийн газраас гаргасан мэдээгээр тус орны гадаад худалдааны нийт эргэлт 2002 онд 620.8 тэрбум ам.долл-т хүрч, экспортын хэмжээгээр (325.6 тэрбум ам.долл) дэлхийд 5-рт, импортоороо (295.2 тэрбум ам.долл) 6-рт орох болжээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах талаараа ч Хятад улс дэлхийд тэргүүлж эдүгээ гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээ нь 500 тэрбум ам.долл-т хүрсэн бөгөөд 2002 оноос жилд гадаадаас оруулдаг хөрөнгө оруулалтаараа АНУ-ыг давах болжээ. Хятад улс сүүлийн жилүүдэд гадаадад хөрөнгө оруулалт хийх, ажиллах хүч гаргах талаар нэлээд идэвхитэй үйл ажиллагаа явуулж байна. Одоогийн байдлаар БНХАУ гол төлөв хөгжиж буй орнуудад 7000 гаруй үйлдвэрт 15 тэрбум ам.долл-ын хөрөнгө оруулалт хийж, 500 мянган хүнийг ажиллах хүч байдлаар гадаадад илгээсэн байна.⁴ Энэ бүхнээс харахад өмнөд хөрш БНХАУ-ын эдийн засгийн тогтвортой өсөлт, зах зээлийн тэлэлт, бүс нутаг, дэлхийн эдийн засагтай эрчимтэй интеграцчлагдаж байгаа нь Монгол орны эдийн засгийн цаашдын өсөлт хөгжил, түүний аюулгүй байдлын гадаад орчинд эерэг нөлөөтэй хэмээн үзэж болох юм.

Хамгийн гол асуудал Хятад улсын нийгэм, улс төр, эдийн засаг цаашид хэр зэрэг тогтвортой хөгжих вэ, ОХУ-ын нэрт нанхиадч М.П.Титаренкогийн хэлсэнчлэн хятад нөхдүүдийн дэвшүүлж буй зорилт, төлөвлөгөө нь ЗХУ-ын задралаар төгссөн хөгжингүй социализм байгуулах гэсэн утопи төлөвлөгөөний ээлжит шинэ хувилбар болохгүй байх эсэхийг нарийн нягт судлах явдал бөгөөд Хятадын хөгжлийн ирээдүй төлөв Монголын төдийгүй дэлхийн улс төр, эдийн засагт гүнзгий нөлөө үзүүлэх болно. Хэрэв Хятад улсын эдийн засаг хямран ганхаж, задрал, уналт үүсвэл Монголын эдийн засаг маш хүчтэй цочролд орох, магадгүй 1990-ээд оны эхэн үеийн хямралт байдал давтагдаж болзошгүй бөгөөд гэхдээ уг хямрал нь өмнөд хөршийн зах зээлээс ихээхэн хараат болсноос улбаатай байх болов уу. Үүнтэй холбогдуулан хэлэхэд нийгмийн ухаан, олон улс судлал болон олон улсын харилцаа судлалын эрдэмтэд, эдийн засагчдын маш чухал үүрэг, зорилго бол Монгол Улсын аюулгүй байдал, тогтвортой хөгжилд эерэгээр нөлөөлөх түүхэн нөхцөл боломж, гарч болзошгүй аюул сөрөг нөлөөллийг урьдчилан харах, үр нөлөө бүхий бодлогын зөвлөмж боловсруулах явдал юм. Тэгээд ч Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 11-р зүйлд "...үндэсний аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгсэл бол баттай мэдээлэл, нарийн судалгаа, тооцооны үндсэн дээр үйл явдлын өрнөлт, хөгжлийг урьдаас харж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах явдал

мөн” гэж заасан билээ. Хятад судлалын эрдэмтэн мэргэжилтнүүд, бодлого боловсруулагчид бүгд оршин буй асуудал, тулгамдсан зорилтуудыг сайн мэдэж буй боловч дээр дурьдсан аюулгүй байдлыг хангах үндсэн арга хэрэгслийг дорвитой ашиглаж, практикт өргөн хүрээнд нэвтрүүлэх шаардлагатай байна. Ний нуугүй хэлэхэд Орос, Хятадын асуудлыг сонирхон уншдаг, мэддэг хүн цөөн бус байгаа боловч дагнасан судалгаа хийдэг, өндөр түвшинд мэргэшсэн, мэргэжлийн боловсон хүчин маш цөөний дээр, мэргэжлийн судлаачид саланги тусдаа, бараг өөрийн хүсэл сонирхлын дагуу, хатуухан хэлбэл чадал чансаа, нөхцөл бололцоондоо тохирсон, цаг үеийн аясыг дагасан үлбэгэр судалгаа хийж байна. Энд манайд үйлчилж буй эрдэм судалгааны ажлыг санхүүжүүлэх хүнд суртлын хөшүүн тогтолцоо, тэгшитгэн хуваарилах механизм ч сөргөөр нөлөөлж байна. Гэхдээ энд бага зэргийн урамшууллын механизм үйлчилж эхэлж буйг хүлээн зөвшөөрч болох боловч угаасаа оюуны хөдөлмөрийн үнэлгээ маш доогуур байгаа нөхцөл байдлыг өөрчилж байж оюуны сэтгэлгээнд шинэчлэлт гарах болно. Өнөөгийн нөхцөлд эдийн засгийн аюулгүй байдалд нарийвчилсан судалгаа хийж, түүнд хяналт тавьж байх гол үндэслэл болох шалгуур үзүүлэлтүүдийн систем бий болгох, үндэсний аюулгүй байдлын тулгамдсан асуудлууд, түүний дотор хөрш орнуудын хүчин зүйлийн талаар бодлогын зөвлөмж, лавлагаа, үнэлгээг тогтмол хийдэг бүтцийг нэн даруй бий болгож, санхүүжилтийн зохистой механизмыг нэвтрүүлэх хэрэгтэй байна.

Одоо Монголын эдийн засгийн аюулгүй байдалд БНХАУ-ын үзүүлэх хүчин зүйлүүдийг дотоод гадаадын эрдэмтдийн дэвшүүлэн тавьж буй зарим шалгуур үзүүлэлтүүдтэй холбон авч үзье. Юуны өмнө манай ихэнх эдийн засагчид эдийн засгийн аюулгүй байдал гэдэг нь гадаад орнуудтай эдийн засгийн хувьд харилцан хамааралтай орших чадвартай, хүн амынхаа сайн сайхан байдлыг тогтвортойгоор хангадаг эдийн засгийн тогтолцоог бүрдүүлсэн байдал гэдэгтэй санал нэгтэй байна. Тэгвэл Монгол-Хятадын эдийн засаг, худалдааны харилцан хамаарал ямар түвшинд байна вэ?

Хятад улстай хийж буй худалдаа жилээс жилд өсөн нэмэгдсээр байна. МХАУТанхимаас саяхан гаргасан мэдээллээр 2003 оны урьдчилсан гүйцэтгэлээр гадаад худалдааны нийт бараа эргэлт 1387,5 сая ам.доллар болж 2002 оны мөн үеийнхээс 172,8 сая ам.доллар буюу 14,2 хувиар нэмэгджээ. Импортын дүн экспортын дүнгээс 187,2 сая ам.доллараар давж, гадаад худалдааны баланс сөрөг хэвээр байв.

Монгол-Хятадын худалдааны эргэлт (1990-2003)

Нэгж: сая ам.долл

	1990	1995	1998	1999	2000	2001	2002	2003*
Нийт эргэлт	33.6	122.3	143.4	285.8	400.1	374.5	388.2	448.3
МУ-ын нийт эргэлтэд эзлэх %	2%	13.8%	19%	29.5%	35%	32.3%	32.0%	32.3%
Үүнээс: экспорт	11.3	77.8	88.4	208.2	274.3	238.3	220.5	276.7
МУ-ын нийт экспортод эзлэх %	1.7%	14.3%	29.3%	45.8%	51.2%	45.7%	42.1%	46.1%
импорт	22.3	44.5	55.0	77.6	125.8	136.2	167.7	171.6
МУ-ын нийт импортод эзлэх %		10.1%	11.6%	15.1%	20.5%	21.3%	24.3%	21.8%

Эх сурвалж: Монгол Улсын статистикийн эмхтгэлүүд

* МХАҮТ –аас 2003 оны урьдчилсан гүйцэтгэлээр гаргасан дүн мэдээ

2003 онд Монгол-Хятадын худалдааны нийт эргэлт 448 сая ам.долларт хүрч, манай улсын гадаад худалдааны нийт эргэлтийн 1/3, экспортын бараг тэн хагас, импортын 1/5-г Хятад улс дангаар эзлэх болсноос харахад Монгол орны гадаад худалдааны хамгийн том түнш бол өмнөд хөрш БНХАУ бөгөөд цаашид ч энэ байр суурь улам бэхжин хөгжих төлөвтэй байна. Өнгөц харахад манай улс Хятадтай хийж буй худалдаанд 170 гаруй сая ам.долл-ын ашигтай харагдаж байгаа нь сайн үзүүлэлт боловч хэрэг дээрээ экспорт нь зэс, молибден, нүүрс, ноолуур, арьс шир гэх мэт стратегийн цөөн хэдэн бүтээгдэхүүнээс голлон бүрддэг, тэдгээр нь зах зээлийн үнийн хэлбэлзэл ихтэй, өөрөөр хэлбэл тогтвортой худалдааны эх үүсвэр муутай, дэлхийн болон Хятадын зах зээлээс ихээхэн хараат гэсэн үг юм. Жишээ нь 1999 оноос Хятадад гаргах экспорт огцом нэмэгдсэн нь дэлхий зах зээл дэх зэсийн баяжмалын үнэ ихэд унасны улмаас ОХУ-д нийлүүлж байсан зэсийн баяжмалыг тээврийн зардал багатай, харьцангуй ойр зах зээл болох Хятад руу гаргаж эхэлсэнтэй холбоотой юм. Мөн манай улсын экспортын гол бүтээгдэхүүн болох зэсийн баяжмал нь 2003 онд биет хэмжээгээр 4,5 хувь, нэгжийн үнэ 12,1 хувиар өссөн бол хонины самнаагүй ноосны экспортын биет хэмжээ 65,2 хувиар өссөн боловч нэгжийн үнэ 14,7 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан байна.

Хятад улс хуурай газраар ОХУ, Монгол, Хойд Солонгос, Казахстан зэрэг 15 оронтой 20 гаруй мянган км газраар хиллэдэг, үүнээс 4677 км нь Монгол Улстай хиллэдэг. Сүүлийн жилүүдэд хил худалдаа өргөжиж, орон нутгийн эрэлт хэрэгцээг хангах, бизнесийн идэвхийг сэргээхэд чухал ач холбогдолтой байгаа хэдий ч нэн даруй шийдвэрлэвэл зохих цөөнгүй

асуудлууд оршсоор байна. Хил худалдаанд оролцож буй хоёр талын аж ахуйн нэгжүүдийн хооронд төлбөр тооцоо, бараа нийлүүлэлт, чанар, үнэ ханштай холбогдол бүхий зөрчил маргаан цөөнгүй гардаг. Мөн түүнчлэн улирлын чанартай нээгддэг хилийн боомтуудын тохижилт муугаас гадна хяналт шалгалт төдийлөн сайнгүй байгаа тул татвараас зайлсхийх, хориотой бараа нууцаар оруулах зэрэг элдэв хууль бус үйлдэл, хэрэг зөрчил олонтаа гарч байна. Хил худалдааны үр өгөөжийг нэмэгдүүлэхийн тулд бүсийн хөгжилтэй нягт уялдуулах, гааль татварын оновчтой бодлого явуулах, үйлдвэрлэл үйлчилгээг дэмжих, экспортын үр ашгийг нэмэгдүүлэх хэрэгтэй.

Монгол-Хятадын худалдааг өргөжүүлэн хөгжүүлэх явцад цаашид судлуулштай нэгэн асуудал бол худалдааны нөхцөл, төлбөр тооцооны асуудал юм. Эдийн засгийн эрх ашгаа хамгаалах, түүнийг эрх баригчдын бодлого шийдвэрт хэрхэн нөлөөлж болох тод жишээг сүүлийн жилүүдэд АНУ-Хятадын худалдааны харилцаанд гарсан маргаан, улс төрийн яриа хэлэлцээнээс тод харж болох юм. АНУ-ын үйлдвэрлэгчид, бизнесмэнүүд, хууль тогтоогчид Хятадыг юаний ханшаа (\$1 = 8.3 юань) 1994 оноос хойш хатуу барьсны улмаас хоёр орны худалдаанд АНУ-ын талын алдагдал асар ихээр нэмэгдэж, 2002 онд оргил цэг буюу 103 тэрбум ам долл.т хүрсний зэрэгцээ 2 сая америкчууд ажлын байраа алдахад хүрсэн хэмээн буруушаах болсон ажээ.⁵ АНУ-ын эрдэмтэд, сонирхлын бүлгүүдийн үзэж байгаагаар юаний зохиомол өндөр ханш АНУ-д оруулж буй Хятадын барааг үнэтэй, Хятадад гаргаж буй АНУ-ын барааг хямдрахад хүргэж байна гэж үзэж Цагаан ордны эрх баригчдыг улс орны эдийн засгийн аюулгүй байдлаа хамгаалах талаар шийдвэртэй арга хэмжээ авахыг шаргуу шаардах болжээ. Үүнтэй уялдуулан авч үзвэл манай ганзагын наймаачид, жижиг дунд компаниуд хятад түншүүдтэйгээ гол төлөв юаниар төлбөр тооцоогоо хийдэг тул юаний ханшны хувьсал өөрчлөлт Монголын зах зээлд хэрхэн нөлөөлдгийг тусгайлан судлуулштай юм.

Эдийн засгийн аюулгүй байдал буюу бие даасан байдал нь гадаад орнууд, тэр тусмаа хөршүүдтэйгээ хэр зэрэг харилцан хамаарал бүхий харилцааг хөгжүүлж, хэр зэрэг оюуны өндөр багтаамж, өртөг шингээсэн, өндөр бүтээмжтэй интеграцид орж чадсанаар хэмжигдэх болсон өнөөгийн цаг үед бид Хятадын аль болох эдийн засгийн олон салбарын болон орон нутгийн эрэлт хэрэгцээг хангахуйц олон төрөл бараа, бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээг дэлхийн зэх зээлийн үнээр санал болгож нийлүүлж чадвал манай улсын эдийн засгийн аюулгүй байдал, хөгжил дэвшил төдий

чинээгээр бэхжих болно. Сүүлийн жилүүдэд газрын тос, нүүрс, цайр, алт, зэсийн баяжмал гэх мэт уул уурхайн салбарын шинэ бүтээгдэхүүн, транзит тээвэр, худалдаа, үйлчилгээг Хятадад нийлүүлэх хүчин чадал нэмэгдсэн буюу нэмэгдэх сайхан бололцоо гарч ирж байна. Шинэ нөхцөл бололцоо нь Монгол Улсын өргөн удам нутаг дэвсгэр, түүний хэвлий дор нуугдан буй эрдэс баялаг, Хятадын зах зээлд ойр орших гэх мэт давуу талуудтай нь шууд холбоотой юм. Чухамжүү эндээс Хятадын том зах зээлд байр сууриа эзлэх, харилцан ашигтай, харилцан хамааралтай оршин тогтнохын үндсэн нөхцөл болох Монгол Улсын өрсөлдөх чадварыг өсгөн нэмэгдүүлэх асуудал урган гарч ирнэ.

Ойрын 10-20 жилд Монгол Улсын хувьд Хятад болон Зүүн Ази, цаашилбал дэлхийн зах зээлд өрсөлдөхүйц боломжтой гол чиглэлүүд бол уул уурхайн бүтээгдэхүүнийг гүн боловсруулан экспортлох, оюуны өндөр багтаамжтай өртөг шингээсэн бараа бүтээгдэхүүн, дээд зэрэглэлийн үйлчилгээг бий болгох гол нөхцөл болох өндөр боловсролтой иргэдтэй болох буюу монгол хүний оюуны өндөр чадавхийг бий болгох явдал юм.

Ямааны ноолуурыг эс тооцвол Монгол Улсаас дэлхийн эдийн засагт оруулах хувь нэмэр болон олон улсын зах зээл дээр өрсөлдөх салбар бол Монгол орны өргөн удам нутаг дэвсгэрийн хэвлий дор нуугдан буй ашигт малтмал эрдэс баялгийн бүтээгдэхүүн юм.

2002 онд Монгол Улсын олборлосон уул уурхайн бүтээгдэхүүнийг дэлхийн олборлолттой харьцуулсан үзүүлэлтүүд⁶

№	Бүтээгдэхүүн	Дэлхийн нийт олборлолт	Монголын олборлолт	Дэлхийд эзлэх хувь	Дэлхийд эзлэх байр
1	Жонп	4530.3 мян. т.	189.7 мян.т.,	4.08%	5-рт
2	Зэс	13.4 сая т.	131.7 мян.т.,	1 орчим %	15-16-рт
3	Молибден	128.0 мян. т.	1590.3 т.,	1.24%	10-рт
4	Алт	2530.0 т.	10.7 т.	0.42%	-
5	Гянтболд	46.6 мян. т.	51.0 т	0.11%	10-рт

Монгол Улсын уул уурхайн салбарын цаашдын хөгжлийн хувь заяанд өмнөд хөрш Хятад улсын эдийн засгийн хөгжил, зах зээлийн эрэлт нийлүүлэлтийн байдал маш их, магадгүй шийдвэрлэх үүрэг гүйцэтгэх төлөвтэй байна. Монгол, Хятад хоёр улсын эдийн засгийн харилцааны тэргүүлэх чиглэл болж буй уул уурхайн салбар дахь хамтын ажиллагаа нь маш өргөн хүрээнд, олон чиглэлээр хөгжих бололцоотой юм: Тухайлбал, харилцан ашигтай худалдаа (гэхдээ гол төлөв Монголоос Хятад руу чиглэсэн экспорт давамгайлсан), дангаар буюу хамтран хөрөнгө оруулалт хийх, хөнгөлөлттэй зээл, буцалтгүй тусламж олгох, гэрээгээр ажиллах хүч оруулах, Монголын уул уурхайн бүтээгдэхүүнийг

Хятадад боловсруулалт хийж гуравдагч орны зах зээлд гаргах, эцсийн бүтээгдэхүүн хийх үйлдвэр барих, ашигт малтмалын ордыг бүтээгдэхүүн хуваах болон ажил үйлчилгээ, дэд бүтцийн бүтээн босголтонд оролцох нөхцөлтэй гэрээ байгуулж ашиглах, тоног төхөөрөмж нийлүүлэх, боловсон хүчин бэлтгэх гэх мэт олон чиглэл байж болох юм. Эдгээрийн дотроос хамгийн эн тэргүүний ач холбогдолтой чиглэл бол Хятадын жилээс жилд эрс өсөн нэмэгдэж буй ашигт малтмал, эрдэс баялгийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахад чиглэсэн худалдаа, хөрөнгө оруулалт юм.

Хятад улсын геологи-хайгуул, уул уурхайн салбар ихээхэн хувьсал өөрчлөлтийн үе шатандаа явж байна. Энэ нь нэг талаас тус орны ашигт малтмал, түлш түүхий эдийн эрэлт хэрэгцээ тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа, нөгөө талаас БНХАУ 2001 оны сүүлчээр Дэлхийн худалдааны байгууллагад албан ёсоор элссэнтэй шууд холбоотой. 1990 оноос хойш Хятадын ээсийн хэрэглээ 110%, хөнгөн цагааных 323%, цайрынх 270%, өнгөт металлынх 260%, газрын тосных бараг 2 дахин өсчээ.⁷ Энэ бүхний дүнд Хятад улс эдүгээ дэлхийн ашигт малтмалын томоохон үйлдвэрлэгч төдийгүй хэрэглэгч болоод байна. 2001 оны байдлаар Хятадын ашигт малтмалын үйлдвэрлэлийн хэмжээ хатуу биет хэлбэрээр 4 тэрбум тоннд, үнийн дүнгээр 479 тэрбум юаньд хүрсний дээр нүүрс, ган, цемент, нефть бүтээгдэхүүний үйлдвэрлэлээр дэлхийд тэргүүлэх болжээ.⁸ 2010 хүртэл үндэсний нийт бүтээгдэхүүний хэмжээг 2000 оныхоос 2 дахин нэмэгдүүлэх зорилт дэвшүүлсэнтэй уялдан Хятадын түлш, эрчим хүч, түүхий эдийн эрэлт хэрэгцээ улам өсөх хандлагатай байна. БНХАУ-ын хувьд эдийн засгийн тогтвортой түргэн өсөлтөө хангахын тулд түлш, эрчим хүч, түүхий эдийн найдвартай эх үүсвэрийг дотоод, гадаадад бий болгох зорилт дэвшүүлж байна. Чухамхүү үүнд Монгол дахь Хятадын геоэдийн засгийн сонирхол төвлөрөх болно.

1990 оноос Монголд гадаадаас оруулж буй хөрөнгө оруулалтын талаар Хятад улс тэргүүлэх байр суурь эзэлж байна. Монгол Улсын Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагаас гаргасан албан ёсны мэдээ баримтаас харахад 1990-2002 онуудад Монгол Улсад нийт 72 орноос 660.5 сая ам долларын хөрөнгө оруулснаас 282 сая нь буюу 1/3-ээс их хэсгийг Хятадын бизнесменүүд оруулсан байна. Гадаадын хөрөнгө оруулалттай компаниудын тооны хувьд ч өмнөд хөрш маань давамгайлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгө оруулалттай 2400 гаруй компаний 847 нь Хятадын хөрөнгө оруулалттай ажээ.

Эдүгээ Хятадаас Монголд оруулж буй хөрөнгө оруулалт хөрөнгийн хэмжээ, байгуулсан аж ахуйн нэгжийн тоогоор давамгайлж байгаа боловч

цаашид анхаарвал зохих нэлээд асуудал байна. Хятадын талын хөрөнгө оруулалтын чанар, үр өгөөж, хэмжээ далайц хоёр орны гадаад худалдааны эргэлт, потенциалтай харьцуулбал ихээхэн доогуур байна. Хятадын хөрөнгө оруулалттай нэг аж ахуйн нэгжилд оруулсан хөрөнгийн хэмжээ харьцангуй доогуур байгаагаас гадна, улсын төсөв, экспортод дорвитой хувь нэмэр оруулахуйц компани одоогоор алга. Хэрэв 1990 оноос өмнө байгуулагдсан, ОХУ-ын хөрөнгө оруулалттай хамтарсан үйлдвэрүүд болох уулын баяжуулах Эрдэнэт үйлдвэр, Росцветмет, УБТЗ-ыг оруулан тооцвол манай эдийн засагт Хятадын хөрөнгө оруулалтын эзлэх байр суурь, нөлөө маш бага гэдэг нь харагдаж байна. Энэ дашрамд хэлэхэд Хятадын нөлөө нэмэгдэх, улс төр, эдийн засгийн хараат байдалд орохоос болгоомжлох байдал Монголын нийгмийн сэтгэл зүйд тодорхой хэмжээнд тогтвортой хадгалагдсаар байдаг.

Сүүлийн жилүүдэд дэд бүтцийн салбар дахь Монгол-Хятадын хамтын ажиллагаа ихээхэн идэвхижсэн бөгөөд цаашид өргөжүүлэх, эрчимжүүлэх их нөөц бололцоо байна. Хятад улс Ховд аймгийн Дөргөний усан цахилгаан станц (хятадын талын зээл -26.5 сая ам.доллар), Эрдэнэсант-Цэцэрлэгийн хатуу хучилттай замын засвар, Налайх-Чойрын хатуу хучилттай 200 гаруй км зам барих зэрэг томоохон төслүүдэд оролцож байна. Хоёр орны засгийн газрын хэмжээнд дэд бүтцийн салбарт “Мянганы зам” төслийг хэрэгжүүлэх, Чойбалсан хот-Аршаантыг төмөр замаар холбох, Эрдэнэт-Мөрөнгийн эрчим хүчний дамжуулах шугам тавих талаар хамтран ажиллах боломж, хэлбэрүүдийг судалж байна. Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эдгээр томоохон төслүүд нь хоёр талын хамтын ажиллагаанд дорвитой түлхэц өгөөд зогсохгүй бүс нутгийн интеграцийг хөгжүүлэхэд, манай хоёр орны харилцааны эрчимтэй хөгжлийн чухал үндэс суурь болох харилцан ашигтай, харилцан нөхсөн шинжийг улам бүр нөхцөлдүүлж өгөхөд чухал хувь нэмэр болох нь дамжиггүй.

Олон зуун хамтарсан компани байгуулагдсан болон барилга, дэд бүтэц, уул уурхайн салбарт хэрэгжүүлж буй олон арван төслийг хэрэгжүүлэхдээ туршлагатай, зохион байгуулалт сайтай, хямд ажиллах хүчийг Хятадаас ихээр оруулж ирэх болсны улмаас сүүлийн жилүүдэд Монгол дахь хятад иргэдийн тоо, Монголын хилээр орж гарсан хятадуудын тоо аль аль нь эрс нэмэгдсэн байна. Үндэсний статистикийн газрын мэдээгээр 2002 онд Монгол улсын хилээр нийт гадаадын 235 мянган иргэн орж ирсэний дотор хамгийн олон нь букуу 92.6 мянга нь БНХАУ-ын иргэд байлаа.⁹ Албан бус мэдээгээр барилга, дэд бүтцийн

салбарт Хятадаас ирсэн 1300 гаруй ажилчин ажиллаж байгаа мэдээлэл байна.

Дүгнэлт, санал

Даяаршлын үйл явцад олдсон боломж бололцоог хэрхэн ашиглах, эрсдэл өрсөлдөөнийг хэрхэн даван гарахаас хамааран ойрын 20-30 жилд Монгол, Хятадын эдийн засгийн харилцааны төлөв байдал, эдийн засгийн аюулгүй байдалд БНХАУ-ын зүгээс үзүүлэх нөлөөг дараах хоёр байдлаар төсөөлж байна. Хятад улс тогтвортой хөгжин дэлхийн худалдаа, аж үйлдвэрийн гол цөм болон хувирч буй үйл явцыг даган Монгол Улсын эдийн засаг өмнөд хөршөөр дамжин Ази, Номхон далайн бүс нутаг улмаар дэлхийн эдийн засагтай гүнзгий интеграцлагдан, Монгол орны онгон байгалиас гарган авсан экологийн цэвэр бүтээгдэхүүн болон байгалийн баялаг, эрдэс түүхий эд улам бүр өсөн нэмэгдэж буй Хятадын болон дэлхийн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангахын хамт Ази-Европыг холбосон Монгол орны газар зүйн байрлалын давуу байдал эдийн засгийн үр ашгаа өгч эхэлсний үр дүнд Монгол орны хөгжлийн хурд түргэсэн, эдийн засгийн аюулгүй байдлын түвшин, мэдрэмж дээшлэхийн зэрэгцээ ард түмний аж байдал эрс дээшлэн сайжрах нөхцөл бололцоо бүрдэнэ.

Хоёр улсын дотоодод тулгарч буй асуудал бэрхшээл болон Монголд нөлөөгөө тогтоох гэсэн их гүрнүүдийн бодлого, сөргөлдөөний улмаас Монгол Улс дэлхийн зах зээл, бүс нутгийн интеграциас орхигдон хоцорч, өмнөд хөршийнхөө түүхий эдийн хавсарга болох, зах зээлээс нь ихээхэн хараат байдалд орж болзошгүй юм. Мөн эрдэс түүхий эдийг эмх замбараагүй ашигласны уршгаар экологийн тэнцвэр алдагдан, үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн сүлжээнд татагдан орох, улс орны бүрэн эрх, бие даасан байдал ганхан суларч, ард түмний аж байдал доогуур зэрэг олон хүчин зүйлийн улмаас гадны оролцоог эсэргүүцэх, ялангуяа Хятадын эсрэг үзэл хүчтэй болж, хоёр талын харилцааны хөгжлийн эрч саарах, эцсийн дүндээ Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд БНХАУ-ын зүгээс үзүүлэх сөрөг нөлөө давамгайлах чиг хандлага гарч болзошгүй юм.

Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдалд БНХАУ-ын зүгээс үзүүлэх нөлөө, хүчин зүйлийг тодруулан гаргахын тулд цаашид дараахь чиглэлээр нарийвчилсан судалгаа явуулах нь зүйтэй болов уу хэмээн үзэж байна. Үүнд:

- Эдийн засгийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх худалдааны түнш орнууд, ялангуяа гол түнш Хятадын эдийн засагт гарч болзошгүй

хямралыг дамжуулах гол суваг нь болох худалдааны нөхцлийг гадаад валютын ханш (түүний дотор юаний ханшны нөлөө), далд эдийн засгийн хүчин зүйлүүдтэй нягт уялдаатайгаар судлах,

- Гадаад хөрөнгө оруулалт, ялангуяа сүүлийн жилүүдэд Хятадаас Монголд оруулах хөрөнгө оруулалт эрс нэмэгдэж байгаатай уялдуулан гадны хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн бодит үр ашгийн судалгааг тогтмол явуулж, төр засгийн байгууллагуудаас явуулах бодлого үйл ажиллагаанд зохицуулалт хийх нөхцлийг бий болгох,

- Монгол Улс хүн ам цөөтэй ажиллах хүчний нөөц багатай орон тул тодорхой хэмжээгээр гаднаас ажиллах хүч авах хэрэгцээ шаардлага байгаа боловч хэдий хэмжээний ажиллах хүчийг ямар нөхцөлтэйгээр, ямар хууль журмын дагуу оруулах, тэдэнтэй холбогдон гарах аливаа асуудлыг хэрхэн зохицуулах талаарх судалгаа, тооцоог нэн даруй хийх шаардлагатай байна. Монгол-Хятадын харилцаанд ажиллах хүч авч байсан, тэдгээрийн эргэн тойронд багагүй асуудал шуугиан гарч байсан түүхэн туршлагаа харгалзахын зэрэгцээ, хөдөлмөрийн насны олон мянган хүн ажилгүй байгаа болон Монголын нийгэмд хятад иргэд нутагшин суурьшихаас эрс болгоомжлон сэрэмжилдэг хүчин зүйлүүдийг ч энд бодолцох нь зүйтэй болов уу.

ИШЛЭЛ, ЗҮҮЛТ

1. Эдийн засгийн хөгжил, аюулгүй байдал. УБ, 2002.; Д.Тунгалаг, Д.Цэрэнпил. Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдлын зарим асуудал. УБ, 2002.; Монгол Улсын эдийн засгийн аюулгүй байдал, шалгуур үзүүлэлтүүд. УБ, 2002.; Глобалчлал ба Монгол Улсын хөгжил. УБ, 2002; Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба гуравдахь түнш орнууд: өнөө, ирээдүй. УБ, 2002.; “Үндэсний эдийн засгийн тусгаар тогтнол, түүний хараат байдлын зэргэмжийг тодорхойлох тухай зөвлөмж”, Шинэ толь сэтгүүл, 1994/1;
2. Дэлхийн хөгжлийн үзүүлэлтүүд// Монгол Улсын статистикийн эмхэтгэл. УБ.2003, х-299
3. <http://www.cia.gov/publications/factbook>
4. КНР: политика, экономика, культура в 2002 г. Москва, 2003 стр, 136.
5. Far Eastern Economic Review. August 21, 2003, pp-16
6. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас Геологи-уул уурхайн салбарын 2002 оны үйл ажиллагааны талаар гаргасан мэдээллийн товхимол. 2003 он.
7. Хятадын Чунцин хотноо 2002 оны 10-р сарын 21-22-нд болсон „Хятадын уул уурхай –2002 онд” сэдэвт бага хурал дээр Хятадын Газар, нөөц баялгийн яамны орлогч сайд Шоу Зяжуагийн хэлсэн үг. www.worldbank.org/odmc/conferences_china.htm
8. Мөн тэнд
9. Монгол Улсын статистикийн эмхэтгэл. УБ.2003, х-299